



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 1/35

Сүмбэр сум

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолын 1 дэх заалт, "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах тухай нийтлэг журам"-ын 5.1 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 40 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Төрийн албаны зөвлөлөөс хянаж, зөвшөөрөл олгосоны дагуу Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Тухайн албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалд томилогдон ажиллаж буй албан хаагч бүрт албан ёсоор танилцуулж, ажиллахыг /Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ХАТАНТӨМӨР

Сүмбэр сумын Засаг даргын Тамгын
газрын даргын 20.12.09 оны 12 дугаар сарын
30 өдрийн 1/8 дугаар тушаалын 4 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын
Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр:

Хөдөө аж ахуйн тасаг

Албан тушаалын нэр:

Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны
асуудал хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Туслах түшмэл, ТЗ-3

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Сүмбэр сумын Засаг даргын Тамгын
газрын байр, Залуучуудын өргөн чөлөө
2-208 тоот

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хүнс, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, гүйцэтгэлийн үр дүнг сумын Засаг даргын Тамгын газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Хүнс, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, удирдан зохион байгуулах;
2. Хүнсний аюулгүй байдлыг хангуулахад хяналт тавих, иргэн аж ахуйн нэгжид мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллах;
3. Иргэн, аж ахуйн нэгж, хоршоонд арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах;
4. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах;
5. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none">1. Хүнс, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэр, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах;2. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүнс, худалдаа үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулан хэлэлцүүлж, батлуулах, хэрэгжилтийг хангах;	<p>Хууль тогтоомж, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>Г</p> <p>Г</p>
2 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none">1. Хүнсний аюулгүй байдал, нийтийн хоолны салбар, худалдаа үйлчилгээний стандартыг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах;2. Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, заавар өгч, хамтран ажиллах;3. Хүнсний аюулгүй байдал, нийтийн хоол, худалдаа үйлчилгээний салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, шинжилгээ дүгнэлт хийж, тайлагнах;	<p>Стандартыг хангаж ажилласан байна.</p> <p>Хяналт шалгалт хийж, стандартыг хангуулсан байна.</p> <p>Мэдээллийн санг бүрдүүлсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
	<ol style="list-style-type: none">1. Иргэн аж ахуйн нэгж, хоршоонд арга зүйн зөвлөгөө өгч, чадавхижуулах ажлыг зохион	Хуульд нийцсэн арга зүйн зөвлөмжөөр хангасан байна.	Г




3 дугаар зорилтын хүрээнд	<p>байгуулах;</p> <p>2. Иргэдийг нөхөрлөл, хоршоо байгуулж ажиллахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, нэгдсэн мэдээ судалгааг гаргах, тайлагнах;</p> <p>3. Малчдаас зах зээлийн эргэлтэнд оруулж буй түүхий эдийн урамшуулал олгох, түүнийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>4. Хоршоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран ажиллах, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчилахад дэмжлэг үзүүлэх, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй болоход дэмжин ажиллах;</p>	<p>Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.</p> <p>Урамшуулал бүрэн олгогдсон байна.</p> <p>Брэнд бүтээгдэхүүнтэй болж, борлуулалт нэмэгдсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г, Т</p>
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Сумын хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, батлуулах;</p> <p>2. Сум хөгжүүлэх сангийн төсөл зарлах, хүлээн авах, эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлүүлэх, мэдээллийн санд оруулж, мэдээлэх, хяналт тавих, тайлагнах;</p> <p>3. Сум хөгжүүлэх сангийн зээлийг зориулалтын дагуу ашиглахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, чиглүүлж ажиллах;</p>	<p>Судалгаа, мэдээ мэдээллийн тоон үзүүлэлт нэмэгдсэн байна.</p> <p>Төсөл шалгаруулалт хууль тогтоомжийн хүрээнд ил тод нээлттэй явагдаж үр дүнд хүрсэн байна.</p> <p>Хуульд нийцсэн зөвлөгөөгөөр хангасан байна</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г, Т</p>
	<p>1. Холбогдох хуульд тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;</p> <p>2. Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх;</p> <p>3. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх;</p> <p>4. Хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах;</p> <p>5. Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх;</p>	<p>Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан байна.</p> <p>Зөрчил дутагдалгүй ажилласан байна.</p> <p>Ёс зүйн зөрчил гаргаагүй, иргэдээс гомдол гаргаагүй байна.</p> <p>Хуулийн хугацаанд үнэн зөв гаргасан байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>



5 дугаар зорилтын хүрээнд	6. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг албан бичиг боловсруулах үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах;	Үүрэг даалгаварыг хуацаанд нь чанартай гүйцэтгэсэн байна.	Г
	7. Байгууллагатай харилцах үйлчлүүлэгчдэд хариуцсан асуудлаар зөвлөгөө, мэдээллийг үнэн зөв хүргэх;	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	Г
	8. Өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гарган холбогдох мэргэжилтэнд өгөх;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангасан байна.	Г
	9. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох;	Олон нийтийн арга хэмжээнд оролцоог хангасан байна.	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой.	
Мэргэжил	Хүнс үйлдвэрлэлт /0721/, Хөнгөн үйлдвэрийн технологи /0723/, материал судлал /0722/ нягтлан бодох бүртгэл /0411/, эдийн засаг /0311/, санхүү, банк, даатгал /0412/, менежмент ба удирдахуй /0413/	
Мэргэшил	Мэргэжлээрээ мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол давуу тал болно	
Туршлага	Мэргэжлээрээ ажилласан бол давуу тал болно	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх; -гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; -бусад.
	Асуудал шийдвэрлэх	-хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх; -өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; -бүтээлч, шинийг санаачлагч, үр дүн, нөлөөг урьдчилж тооцдог байх; -албан үүргээ мэргэжлийн түвшинд бүрэн хариуцах; -бусад.
	Багаар ажиллах	-өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; -багийн хүрээнд өөрт ноогдсон үүргээ гүйцэтгэх;



		-Багийн хүрээнд өөрт ноогдсон үүргээ гүйцэтгэх; -Багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах ;
	Бусад	-Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; -Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллах; -Компьютерийн хэрэглээний текстэн, хүснэгтэн, үзүүлэн бэлтгэх програм болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх; -Албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; -Төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн чадвартай байх;

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u> -Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар -Аймгийн Мэргэжлийн хяналтын газар -Сумын Засаг дарга, сумын Засаг даргын орлогч -Төрийн болон төрийн бус байгууллагууд -Олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагууд -Иргэн, аж ахуй нэгж
---	---

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал :</u> САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> ...19...09...16 <u>Дугаар:</u> ...40.....

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН

Байгууллагын нэр:

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: ... 2019.12.30

Дугаар: ... 35

(тамга/тэмдэг)
ДАРГА



(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20.19оны 12 дугаар сарын 30-ны өдөр